



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/535

Мөрөн сум

Сонгон шалгаруулах хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.3, 15.23 дахь заалт Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/565 дугаар тушаал заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга:

- Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
М.Үүрийнбаяр (Эрүүл мэндийн газрын дарга)
Г.Аззаяа (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Б.Оюун-Эрдэнэ (Эрүүл мэндийн газрын эдийн засагч, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нягтлан бодогч)
Б.Сумъяабат (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн)
Т.Амартүвшин (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны нягтлан бодогч)

Хорооны нарийн бичгийн дарга:

- Н.Амарбаясгалан (Нэгдсэн эмнэлгийн Дотоод хяналт аудитын албаны дарга)

2. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/565 дугаар тушаал болон бусад хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй ил тод зарлан журмын дагуу шударга зохион байгуулахыг сонгон шалгаруулах хорооны дарга гишүүдэд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /М.Хуягбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

